



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

“Хөвсгөл дулааны станц”
төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.5 дахь заалт, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн нүүрс тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, компанийн үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд хүнд даацын өөрөө буулгагч машин худалдан авах шаардлагыг харгалзан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 668 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний зарим үзүүлэлтийг 1 дүгээр хавсралтын дагуу өөрчилсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 668 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хөрөнгө оруулалт хэсэгт 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 668 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны их засвар, техник, зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний техник, зохион байгуулалтын арга хэмжээ хэсгийн 3-д заасан “Нүүрсний дээж үзэх тоног төхөөрөмж-45.0 сая төгрөг” гэснийг “Нүүрсний дээж үзэх тоног төхөөрөмж-75.0 сая төгрөг” гэж өөрчилсүгэй.

4.Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон техник, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан компанийн 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

5.Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Ч.Цогоод даалгасугай.

000230

6.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР


Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
402 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшний тодотгосон үзүүлэлтүүд**

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он			Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Тодотгол төлөвлөгөө	2018 тод төлөв/2018 төлөв (хувиар)	2018 тод төл-2018 төл	
	Нийт орлого	мян.төг	4 343 506,4	4 913 926,0	4 991 056,3	101,6	77 130,3	
3	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	4 074 715,8	4 904 426,0	4 957 285,3	101,1	52 859,3	
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	268 790,6	9 500,0	33 771,0	355,5	24 271,0	
4	Нийт зардал	мян.төг	4 589 905,1	4 913 702,1	5 090 472,3	103,6	176 770,2	
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	33 910,1	68 161,9	71 862,5	105,4	3 700,6	
5	Татварын өмнөх ашиг	мян.төг	-229 906,3	223,9	-99 416,0	-44 401,97	-99 639,9	
6	Цэвэр ашиг	мян.төг	-229 906,3	201,6	-99 416,0	-49 313,49	-99 617,6	
	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	17 417,7	61 023,3	19 076,0	31,3	-41 947,3	
7	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	мян.төг	15 683,8	56 923,4	15 709,9	27,6	-41 213,5	
	Эдэлбэр газрын төлбөр	мян.төг	1 256,8	2 200,0	1 466,3	66,6	-733,7	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	133,0	133,0	147,0	110,5	14,0	
9	Нийт цалингийн сан	мян.төг	1 129 985,5	1 395 488,7	1 554 004,4	111,4	158 515,7	
11	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	874,4	874,4	881,0	100,7	6,6	
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг	төг	71104,9	64654,0	66979,9	103,6	2325,9	
15	ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	мян.төг	33 128,5	796 350,0	1 276 744,8	160,3	480394,8	
16	Байгаль орчны шинэчлэл	мян.төг	0	9 619,2	6 248,0	65,0	-3 371,2	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн
422 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**“Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд
нэмэх төсөл, арга хэмжээ**

Д/д	Хийгдэх ажлууд	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
Хоёр. Хөрөнгө оруулалт					
34	Камержуулалт	ком	1	3400,0	3400,0
35	Стандарт автомашин	ширхэг	1	112000,0	112000,0
36	Хүнд даацын өөрөө буулгагч машин		2	163000,0	326000,0
37	Компьютер-Dell /принтер Samsung-2020/	ком	1	3229,8	3229,8
38	Компьютер	ширхэг	1	2835,0	2835,0
39	Компьютер	ширхэг	1	2930,0	2930,0
	Нийт дүн				450394.8